

ХЭЛНИЙ ЭКОЛОГИЙН ҮНДСЭН АСУУДАЛ

Ч. Баттулга*

Австрали, Манжуур, Төв Ази, Дундад Ази, Бага Ази, Африк, Латин Америк, Амазонг мөрний сав газрыг хамарсан нүүдлийн соёлт ард түмэн (нүүдэлчид) түүхийн урт хугацаанд суурьшмал иргэншилд шилжжээ. Эдгээрээс нүүдлийн ахуй, соёлоо ямар нэг хэмжээгээр хадгалж ирсэн цөөн улсын нэг нь манай орон юм.

“Харин хорьдугаар зууны сүүлчийн хагасаас даяариллын үйл явц хурд хүчээ авч амнаас ам дамжин айлаас айлд халдварлан их түргэн тархах боллоо. Үүний гол нууц нь, гол хөдөлгөгч хүч нь шинжлэх ухаан техникийн хувьсгал буюу оюуны хувьсгал юм. Хүн ард, улс гүрнүүдийг өөр хооронд нь зааглаж байсан орон зай, цаг хугацааны хүчин зүйлсийг шинжлэх ухаан техникийн нээлтүүд эргэлт буцалтгүй өөрчилж чадлаа. Шинжлэх ухаан, техникийн дэвшил ийнхүү даяариллын үйл явцыг түргэсгэх бодит хүчин зүйл болон хувирлаа. Хоцрогдон орхигдохыг хүсэхгүй л бол даяариллын ийм маягийн эргүүлгэнд татагдан орохоос зайлах газаргүй боллоо.”¹ “Суурьшлын соёл иргэнилийн ноёрхол, нүүдэлчдийн соёл иргэнилийн уналтын явц хэдэн зуу, хэдэн мянган жил үргэлжлэх нь тодорхойгүй авч хүн төрөлхтний соёл иргэнилийн өнөөгийн энэ байдлыг хөгжлийн сүүлийн шат хэмээн үзвээс тэр нь ухвар мөчид бодсоных болой. Үүнийг тайлбарлахыг оролдвоос, суурьшлын соёл иргэнилийн цэцэглэн мандаж оргилдоо ойртохын хирээр тэнд хүн, байгаль хоёрын зөрчил тэмцэл дээд хэмжээнд хүртлээ хурцдаж, байгалийн тэнцвэрийн хууль зөрчигдөж амьд байгаль төрөлх онгон байдлаа их хэмжээгээр алдах зэргээр хүний оршин тогтноход аюул занал учирна. Үүнийг одоо үед экологийн аюул хэмээх болсон.”²

“1940-өөд оноос манай оронд нэгдсэн төлөвлөгөөтэйгээр аж үйлдвэр, тээвэр, холбоо, барилга зэргийг эрчимтэй хөгжүүлж, улмаар шинэ хот сууринг олноор байгуулж эхэлжээ. Чухамхүү энэ үеэс хотжих үйл явц эхэлсэн. Үйлдвэрийн хот суурингууд олноор байгуулагдсанаар хөдөөнөөс хотод шилжин суурьшигчдын тоо эрс нэмэгджээ. Энэ үзэгдэл нийслэл Улаанбаатар хотод илүү хурдацтай явагдаж байлаа. 1956 онд хөдөөгийн хүн ам, хотын хүн амаас 3,6 дахин их байсан бол 2000 оны хүн амын тооллогын мэдээгээр хот сууринд 1344,5 мянган хүн, хөдөө нутагт 1, 029.0 мянган ам суурьшиж байна.”³

* МУИС-ийн МХСС-ийн багш, докторант


¹ Л.Түдэв (2001) *Даяарил ба эх оронч үзлийн үндэсний дианетик* // Монгол иргэнилийн үлэмж өв. 135-144 х., Улаанбаатар.

² Н.Хавх (2004) *Соёл иргэнилийн онол*, Улаанбаатар. 217-р тал

³ Д.Хүрэлмаа (2004) 1990-ээд оны хотжилт // *Монголын хүн ам сэтгүүл*, №6, 50-р тал. Улаанбаатар.,

“1992 оны шинэ үндсэн хуулиар Монгол улсын иргэдэд түр буюу байнга оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхийг баталгаажуулж өгснөөр хөдөө орон нутгийн иргэд сурч боловсрох, амжиргаагаа дээшлүүлэх зорилгоор хот суурин газар луу нүүн шилжих үйл явц дахин эрчимжсэнээр 2010 оны жилийн эцсийн тооллогын дүнгээс харахад, нийт хүн амд (Монголын нийт хүн ам 2754685) хотын хүн амын эзлэх хувь 68% буюу 1798, 1 мянган хүн хот суурин газар амьдарч байна.”⁴

Хотжилтын түвшин, 1969-2008, Монгол Улс



Нийгмийн энэхүү үзэгдэл нь тухайн хэлний үгийн сан, үг бүтэх ёс, хэл найруулгад хэрхэн нөлөөлж, яаж өөрчлөгдөн хувьсч байгааг нийгэм хэлшинжлэл судалдаг.

“Нийгэм хэлшинжлэл (socio-linguistics) гэдэг нэр томъёог анх 1952 онд Америкийн эрдэмтэн Н.С. Currie. *A projection of socio-linguistics: the relationships of speech to social status*. “Southern Speech Journal”, 18, 1952, 28-37 гэсэн өгүүлэлдээ анх хэрэглэсэн гэж үздэг.

Нийгэм хэл шинжлэл нь:

Нэг, Хэлний нийгэм, нийгмийн элементийн хэлд үзүүлэх нөлөө, тусгал, хэлний элементээс нөлөө тусгал,

Хоёр, Хэлний хувилбар, нийгмийн хувиралт нь хэлний үгсийн сан болон хэлний зүйг хэрхэн хувируулдаг тухай,

Гурав, Хэлэхүйн хувилбар, тодорхой нэгэн хэлний хэрэглээний орчин болон харилцааны явцаас хэлэхүйн онцлог болон зөрөөг тодруулна.

Дөрөв, Хос хэлний үзэгдэл, тодорхой нэгэн нийгмийн бүлэг хоёр буюу хоёроос дээш хэл солбиулан хэрэглэх явц дунд илрэх нийгмийн ба хүмүүсийн үзэл, сэтгэлгээний илрэл, жич тэдгээр илрэл нь аль хэлийг сонгож хэрэглэхэд хэрхэн нөлөөлж байдаг тухай судална.

Тав, Ярихуйн задлалт хийнэ. Харилцаж байгаа хоёр этгээдийн хэл яриаг задлан шинжилж, харилцаа ярилцааг зохион байгуулсан нийгэм, жич хүмүүс сэтгэлдгээ, хэрэглэгдэн буй хэл, хүрээлэн буй орчин зэрэг бүрэлдэхүүн болон тэдгээрийн дотоод холбоог тодорхойлох, хэл шинжилгээг ярианы хүрээ, хүртэл өргөтгөнө.

⁴ Ц.Болормаа, (2011) *Хотжилт, хотын өсөлтийн байгаль орчны асуудлууд*, Монгол улсын хүний хөгжлийн илтгэл, 6-р тал, Улаанбаатар.,

Зургаа, Хэлний чадавхи, хэлний эл зүйлийн чадал чадавхийг судална. Жишээлбэл: харилцааны чадавхи, сэтгэлгээний чадавхи, сураг нэвтрүүлэх чадавхи зэрэг болно.

Долоо, Хэл бичгийн төрийн бодлого, нийгмийн хөгжлийн хэрэгцээг үндэслэж шинжлэх ухааны үндэс баримт бүхий төрийн бодлогыг тогтоон хэрэгжүүлэх, хэл бичгийн бүтээн байгуулалтыг ахиулж, хэлний төсөв боловсруулах, тухайлбал: тодорхой нэг хэл нь тухайн улс оронд ямар байр суурь эзлэх, улс гүрний хоорондын харилцаанд ямар хэлийг хэрэглэх, нийгмийн эл хүрээнээ эл тусгай мэргэжил, эл сурвалж шинжилгээнд тусгай тусгай нэр томъёог хэрхэн боловсруулах ба нэгтгэх зэргийг судална.”⁵

Үүнийг монгол мэндчилгээний үг хэллэгийн жишээгээр үзүүлье!

“Монголчуудын мэнд мэдэх ёс бас сонин бөгөөд үйл үйлс бүтэх, жаргал цэнгэл дүүрэн байх бэлэгдэл утгыг агуулсан, үг хэлний хувьд товч бөгөөд яруу цэцэн цэлмэгээр шүлэглэсэн байдаг.”⁶

Жишээ нь:

Сар шинийн мэндчилгээний үг:

-Хуучин жил хангирч

Шинэ он шилжирч

Хөгшид хүүхэд хөрстэй

Төлөг сүүлтэй

Даага далантай

Бяруу булчинтай

Өнөд тарган

Өөг цатгалан

Тавтай сайхан шинэлж байна уу...

Хонь хяргаж байвал:

-Хайч нь хурц

Хайчилсан хонины

Тоо нь бум хүрч

Тоос нь огторгуйд хүрэг

Унгас нь уулын чинээ

Дэвжээ нь дэлхийн чинээ болог...

Энэ мэт мэндчилгээний үг хэллэг нь ихэвчлэн толгой холбон шүлэглэсэн хэмжээний хувьд урт байдаг онцлогтой. Ийнхүү толгой холбон шүлэглэсэн, хэмжээний хувьд урт байдаг онцлог нь зөвхөн мэндчилгээний төдийгүй тухайн үеийн монгол хэл, найруулгын нэг онцлог байсан тухай манай эрдэмтэд тэмдэглэсэн байдаг. Тухайлбал: Профессор С.Галсан “Ажиглахад манай судар бичгийн хэлний өгүүлбэр нь ер нь уртавттар, яриандаа очихоор богиносдог онцлогтой. Ахмад зохиолчид Ядамсүрэн, Буяннэмэх (Б.Ренчин) нарын зохиолын өгүүлбэрүүд ер нь урт урт өгүүлбэр голлох нь олонт таарч байдаг”⁷ хэмээсэн байдаг.

Харин өдөр дутмын мэнд мэдэхдээ “Та амар байна уу? Та амар сайн байна уу? Сайн байна уу? Мал сүрэг тарган тавтай юу?” гэх зэргээр хэлдэг бол улирлын мэнд

⁵ С.Хичээлтү (1998) Нийгэм хэл шинжлэл, хэлний төрийн бодлого., 15-16 тал, Хөх хот.,

⁶ Р.Батаахүү (1991) Монголчуудын сурган хүмүүжүүлэх гэрийн уламжлал. 20-р тал, Ховд.,

⁷ Б.Пүрэв-Очир (1988) Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрзүйн холбох тогтолцоо (Редакторын үг)., Улаанбаатар.,

нь “Хаваржаа (өвөлжөө, зуслан, намаржаа) сайхан уу? гэх буюу “сайхан хаваржисж байна уу? ” гэж хэлдэг.

Гэтэл сүүлийн үед мэндчилгээний үг хэллэг –юу байна, юмгүй. hi, bye... гэх мэтээр хураагдан товчлогдох болов. Ингэж мэндчилэх, ярих нь буруу, эх хэлээ эвдэж байна гэх хүмүүс цөөнгүй байна.

Харин нэрт хэл шинжлэлч С.Нямсүрэн “Хэл шинжлэлийн мэргэжлийн бус хүмүүс ингээж ярих нь буруу” тэгж ярих нь зөв гэж хүний хэлэх ярихын жорыг тогтоох гэж яддаг. Жишээ нь: “тавагны” гэж бичих нь буруу, “тавагийн” гэх нь зөв гэх буюу “хоёрт” гэх нь зөв “хоёронд” гэх нь буруу гэх мэтээр маргадаг. Угтаа хэл шинжлэл энэ мэт асуудлыг төдийлөн анхаардаггүй юм. Хэл шинжлэл бол хэлийг задлан шинжлэх асуудлыг гол болгон сонирхоно. Гэхдээ хэл шинжлэл буруу үг хэллэгийн өмгөөлөгч биш гэдэг нь мэдээж. Харин хэлний бүтцийг задлан шинжлэгчийн хувьд “зөв” болон “буруу” хэлбэрийг хоёулангийн нь хамт судлан тэдгээрийн хооронд алгааны систем байгаа эсэхийг олж тогтооно”⁸ гэсэн нь бодууштай үг.

Үнэхээр, эмч хүн өвчтөнд чиний өвчин “зөв өвчин” чинийх “буруу өвчин” гэдэггүйн адил хэлний аливаа асуудалд хэл шинжлэлч нар “зөв” “буруу” гэдэг байдлаар хандамгүй байна.

Угтаа, өнөөгийн хүүхэд залуусын ийн мэндчилж, ярьж байгаа нь хотжилт, хүн амын төвлөрөлттэй шууд холбоотой юм. Өөрөөр хэлбэл, өнөөдөр нийгмийн болон хүний сэтгэлгээний хөгжлийн хурдтай хэл ч уялдаж эхэлж байна. Энэ нь нэг талаас хүн, тэрэг зайгүй хөлхөлдсөн, их хотын “замбараагүй” амьдралд

-Өвс нөгөө, сүү цагаа элбэг, тарган сайхан хаваржисж байна уу?

-Тавтай сайхан зусаж байна уу? Газрын гарц, малын тарга хүч сайн уу?..

гэсэн хөдөө хээр, уудам талд мал сүргээ хариулж яваа нүүдэлч малчдын мэндчилгээ тохирохгүй болсон, нөгөө талаас цаг нартай уралдан ажил төрлөө амжуулдаг их хотын хүмүүсийн хувьд уулзаад хөөрөглөн тамхилаад, цаг агаар, амьдрал ахуйгаа яриад зогсох цаг хугацаа хомс байдгаас шалтгаалан үүдсэн хэрэг. (Мөн энд зарим хэлц үг хэллэгийн хэрэглээний асуудлыг ч ярих ёстой. Мал дагавал ам тосдох нь үнэн боловч тугал хараад туулай гэж хэлд орж буй хүүхдийн сэтгэлгээ ямар байх бол..)

Ийнхүү мэндчилгээ төдийгүй бичгийн болон ярианы өгүүлбэр (ярианы)-ийн хэмжээ ч хураагдан богиноссоор байна. Мөн даяарчлагдахын хирээр харь хэлний нөлөө ч ихэссээр. Тэр ч байтугай “интернетийн хэл” (чаат, мээссээж, мээсэнжэр) гээч юм тогтож эхэлсэн байна. Тэдэнд үзэл бодлоо илэрхийлэх, мэдээллийг хир хурдан дамжуулах нь чухал болохоос ямар үсэг бичгээр бичгээр тэмдэглэх, зөв бичгийн дүрмийн алдаатай эсэх нь чухал биш болжээ. Нийтлэлч Гаампын (Gump) “Манайх наприйшиг түлдэг” нийтлэлээс жишээ болгон үзүүлье.

“Сая нэг муу дураак яаваа. Гадамжинд шаал танихгүй дураак барьж авсанаа чам шиг хөдөөний хөөсөн мантуунуудаас болж хот маань муухай болжээн гэж авдаг гэнээ. Хуцжаагаа шүү хотод орж ирээд арав гаруй жил болоод шаал хотын хүн болчоод байхад. За тэрчяаху. Саяханаас энэ улс төрч, дарга марга хүмүүс дандаа гэр хорооллынхон утаа гаргаж байна, газраа зарж байр бариулахгүй байна гэж ярьдаг болж. Утаа гаргахгүй гээд хөлдөж үххүү дээ. Чадкуу за гээд хэлчмээр санагдаад байдаг болж. Бас байрад орхыг хүсэлгүй яахав дээ. Хамгийн ихээр хүсэж байгаа шүү дээ. Ямар сайндаа “Нэг насаар гэр хороололд байснаас Нэг өдөр байранд байсан нь

⁸ С.Нямсүрэн (1999) Хэл хэлэхийн учир. Улаанбаатар.,

дээр” гэж цаад гудамжинд чинь дуулж байна шүү дээ. Энд гэр хороололд байгаа бидний зовлонг дулаан байранд байгаа дарга нар **ойлгохуу даа**”⁹. Эндээс иргэншил, даяаршил, хотжилт төвлөрлийн улмаас өөрчлөгдөн хувирч байгаа эх хэл, соёлынхоо унаган төрхийг хэрхэн хадгалах, хамгаалж хөгжүүлэх вэ? гэдэг асуулт урган гарна.

Үүнийг эрдэмтэд эко хэлшинжлэл (*eco-linguistics*)-ийн цөм хэлний экологи (*linguistic ecology*) хэмээх ойлголтод хамруулан судлах болсон.

Профессор Ш.Чоймаа “Монгол хэлний экологи буюу монгол хэлбичгээ хамгаалах, тийм боломжит орчныг хадгалахад давын өмнө анхаарах юу юу байна вэ гэдгийг товч өгүүлье.

1. Хүн төрөлхтний хэлийг амьтан ургамлын ертөнцтэй зүйрлэвэл, түүний нэгэн томоохон төрөл зүйл нь монгол хэл бичиг юм. Амьтан ургамлын төрөл зүйлийг хамгаалахад, гарал үүслээс аваад, өнөөгийн тархац хүртэл судлаж, бүх талын орчин нөхцөл хэрхэн нөлөөлж ирсэн, одоо ямар байгаа зэргийг хамтад нь авч үздэг ажээ. Монгол хэл бичгээ сайн мэдэж байвал, хамгаалах болон, боловсруулан хөгжүүлэх арга замыг олж харна.

2. Хэлийг хамгаалах нь улс үндэстний, хамт олны үйл хэрэг боловч, тухайн хэлийг өвлөн авч яваа хувь хүний идэвх зүтгэлээс шууд хамаарна гэж хэл шинжлэлтнүүд бичжээ. Энэ бол гарцаагүй үнэн. Та монгол хүн юм бол, монгол хэл бичгээ зайлбаргүй мэддэг байх ёстой хэмээсэн бичигдээгүй хуулийг хэрэгжүүлж, бас монгол хэлээ мэддэггүйгээ мэддэггүй хүмүүсийг ухааруулах аваас монгол хэлний дархлаа буй болно.

3. Үгээр тоглогчидтой тэмцэх хэрэгтэй. Эх хэлнийхээ үг бүрийг, эх орныхоо чулуу бүрийг хамгаалах цаг иржээ. Аливаа хэлний үг гэдэг үнэ цэнэтэй, ид шидтэй, нарийн нандин зүйл. Үг бүрийн цаана тухайн үндэстэн угсаатан бээр уг юм үзэгдлийг аль талаас, хэрхэн ухаарсныг тусгасан хэл сэтгэхүйн сонин содон дүр төрх байдаг”¹⁰

хэмээн хэлний экологийн үндсэн асуудлыг маш оновчтой тодорхойлжээ.

Өөрөөр хэлбэл, Нэгд, Монгол хүүхэд бүр нялх балчираас үндэсний хэл бичгээ заавал эзэмших, монгол хэл судлаач эрдэмтэн багш бид хэл юүгээн сайтар судлахын зэрэгцээ, үр өгөөжтэй заан сургах (их дээд сургуулийн багш нар сайн багш бэлтгэх), Хоёрт: хэлээ хамгаалж, хөгжүүлэхэд иргэн бүрийн оролцоо нэн чухал болохыг ард иргэдэд ухааруулан сэнхрүүлэх. (Үүнийг монгол бичгийн жишээгээр тусад нь өгүүлнэ.) Гуравт, Олон нийтэд хамгийн их хүртээлтэй тул бүхий мэдээллийн хэрэгсэлийн хэл найруулга, киноны орчуулга, зар сурталчилгааны хэлийг журамлах, төрийн болон төрийн бус байгууллагын албан хэргийг улсын стандартын дагуу хөтлүүлэх зэрэг нь монгол хэл, бичгээ хамгаалах дархлааг буй болгох гол арга юм. Энэ удаа бид нэгдэх асуудлыг хөндөн өгүүлье.

“Монгол ардын сурган хүмүүжүүлэх зүйд тоо хэлбичиг хоёрыг боловсролын агуулгын гол зүйл гэж үздэг бөгөөд тухайлбал эр хүний арван гурван эрдмийн дотор “үгэнд цэцэн” байхыг заасан нь цэцэн цэлмэг хэллэгтэй, зөв сайхан ярьдаг байхыг эрхэмлэдгийн гэрч юм. Хүүхэд залуусыг “үгэнд цэцэн” болгох буюу хэлний соёлыг төгс

⁹ Гаамп (Gump), (2011 оны 9 сарын 5) “Манайх нарийншиг түлдэг” нийтлэлээс, www.niitlelch.gump.mn.

¹⁰ Ш.Чоймаа (2009) Хэлний экологи // Монгол судлал. Том. XXX (318), 125-134 х., Улаанбаатар.,

эзэмшүүлэхдээ ардын аман зохиолын олон зүйлсийг сургалтын хэрэглүүр болгож ирсэн хэрэглэгдэхүүнийг шинэслэн үзэхэд авиа, бүтээвэр, үг, үг холбох зарчим гэж хуваан ангилж болохуйц байгаа нь манай ард түмэн хэлзүйн үндсэн ойлголтыг эртнээс мэдэж байсны гэрч юм.¹¹

“Ялангуяа монгол хүн “ Зөв сайхан мэндэлж сурна гэгч нь хүнтэй зөв боловсон харьцах анхны шат юм. Харьцаа гэгч нарийн зүйл. Иймд хүүхдийг хэлд ормогч хэлж сургах үг бол мэндчилгээний үг хэллэг, мэндлэх ёс болно”¹² гэж үздэг. Өөрөөр хэлбэл, монгол гэрийн сургуулийн багш болох эх, эцэг нь үр хүүхэддээ мэндлэх хүндлэх ёсноос авхуулаад хүн болх ёсны бүхий л зүйлийг заан сургадаг байжээ.

Орчин үеийн сургууль бий болсноос хойш хүүхэд залууст зөв сайхан ярьж, бичих чадвар (Монгол хэл бичгээ сайн мэдэж байхыг)-ыг эрдэмтдийн боловсруулсан стандартын дагуу, монгол хэл, хэл бичгийн хичээлээр олгох болсон. “Монгол хэл, уран зохиолын боловсролын стандарт” хэмээх баримт бичгийг манай нэртэй эрдэмтдийн баг боловсруулжээ. Үүнд, **Монгол хэлний боловсролын зорилго нь суралцагчдад ярианы болон бичгийн соёл эзэмшүүлж, эх хэлний боловсролоо нийгмийн харилцааны янз бүрийн орчинд бүтээлчээр хэрэглэж чаддаг цогц чадамж бүхий иргэн төлөвшүүлэхэд оршино** гэжээ.

Харамсалтай нь, Сурагчид монгол хэлний хичээлээр зөв сайхан ярьж, бичих чадварыг (Монгол хэл бичгээ сайн мэдэж чаддаггүй гэсэн үг) сайн эзэмшиж чаддаггүй болох нь тодорхой байна. Үүнд цөөнгүй шалтгаан буй агаад нэгдэх нь:

Монгол хэл бичиг заан сургах зүйн уламжлал алдагдсан байна

“Энэ сэдвийг сонгон 1960-иас 1995 оны хоорнод хэвлэгдсэн АШС-ийн зөвхөн 1-р ангийн монгол хэлний сурах бичгүүдэд анализ хийж үзэхэд:

1961-1972 оны сурах бичгийн 9,7%

1972-1978 оны сурах бичгийн 10%

1978-1984 оны сурах бичгийн 25%

1984-1995 оны сурах бичгийн 36%-д ардын аман зохиолын зарим төрөл зүйлээс дурьдах төдий жишээг нөхөх, хуулах дасгалыг хэлбэрээр оруулсан нь энэ чухал сэдвийн сурган хүмүүжүүлэх ач холбогдол үүрэг нөлөөг дутуу үнэлсэн, сурах бичиг хэт онолжих хандлагатай болсныг харуулж байна. ШУ-ны тодорхой ойлголтыг жишээ дасгалаар өгөх нь зүйн хэрэг боловч, бие хүнийг төлөвшүүлж байгаа гэдгээ бид мартаж учиргүй. Иймээс хүүхэд багачууддаа сургаж ч, хүмүүжүүлж ч чаддаг байсан монгол ардын уламжлалт аргаас тодорхой системтэйгээр суралцуулах нь өнөөдрийн сургуулиудын хойшлуулалгүй зорилго болж байна.¹³ “Америк мэтийн хожуу хойно бусдын газарт нүүж очсон, үүсэж бий болсон үндэстний хувьд уламжлалт нийгэм, түүний эрэлт хэрэгцээгээр буй болсон, уламжлалт боловсролын тухай ярих юм ч үгүй болов уу? ...Боловсролын агуулгын энэ хоёр талыг шүтэлцүүлэх нь түүхэн зайлшгүй чухал зүйл, эс тэгвээс түүнээс гарах урхаг, үр дагавар нь ноцтой. Хэрэв зөвхөн уламжлалт боловсролоороо улс орноо авч явна гэвэл хүн төрөлхтний хөгжил дэвшлийн орчин цагийн нийтлэг замд орж чалахгүй болж, хоцрогдлын туйлд унана. Хэрэв орчин цагаа дагаж байна гээд уламжлалт боловсролоо ор тас орхиод дан ганц европын

¹¹ Х.Сампилдэндэв (1991) Монгол өрх гэрийн ёсон., 63-р тал, Улаанбаатар.,

¹² Р.Батаахүү (1991) Монголчуудын сурган хүмүүжүүлэх гэрийн уламжлал. 21-р тал, Ховд.,

¹³ Ч.Базарханд (2002) Хүүхдийг эх хэлд нь сургаж байсан ардын уламжлалаас// Монгол судлал, улстөр, эдийн засаг, гүн ухаан, хууль зүй. Том 18 fasc 1-7 х,7-р тал, Улаанбаатар.,

боловсролын тогтолцоог хэрэгжүүлвээс, тэндээс монголын онцлогт таарч тохирохгүй өдий төдий юм гарч, шинэслэх ухаан үйлдвэрлэл хоёр, боловсрол практик хоёр, сургалт амьдрал хоёр нэг нь нөгөөдөө таарч тохирохоо бовьж, эцсийн бүлэгт боловсролын тогтолцоо нь нийгмийнхээ эрэлт хэрэгцээг хангаж эс чадан задрана. Нийгмийг түүний онцлогт нь нийцэх үзэл баримтлал, ухаанаар эс өөрчилж шинэчлэвээс түүнийг экологийн аюулд унагана.¹⁴

Тэгээд ч, Уламжлалаа умартсан улс орон хөгжин дэвших нь юу л бол, дэлхийн хөгжилтэй орнууд болох Япон, Солонгосын хөгжлийн нууц бол үндэсний уламжлал, орчин үеийн техник технологийн дэвшлийг хослуулсанд оршдог.

Хоёрдугаар шалтгаан: Монгол хэлний хичээлийн агуулга, стандарттай холбоотой байна. Үүнд:

1. Хэдийгээр стандартад суралцагчдад ярианы болон бичгийн соёл эзэмшүүлнэ гэсэн атлаа ярианы соёл эзэмшүүлэх талаар, **эхийг уншаад ярилц** гэсэн улиг үгийг эс тооцвол, ямар ч мэдлэг олгодоггүй. Өөрөөр хэлбэл, Сурагчдад мэндлэх хүндлэх, зөв сайхан ярих соёлд суралцах талаарх хичээл огт заадаггүй

2. Бага (1-4) ангийн сурах бичиг төвшингийн болоод бичвэр хоорондын ялгаа, уялдаагүй, сурган хүмүүжүүлэх ач холбогдолгүй, орчуулгын бичвэр ихтэй байна. Хатуухан хэлэхэд, Эдгээр монгол хэлний сурах бичиг нь учир холбогдолгүй эрээвэр хураавар бичвэрийн цуглуулга болжээ. Бичвэр (*текст*) уншаад асуултанд хариулсан болоод, бичвэрээс үг үсэг түүх, нөхөх төдийхнээр гурван жилийг өнгөрөөнө гэдэг хүүхдэд уйтгар гунигтай байхаас ч аргагүй биз ээ.

3. Ерөнхий боловсролын стандартын агуулга хэтэрхий онолын мэдлэг олгоход чиглэгдсэн хэвээр байна. Үүнийг бид 1990 оноос хойш ярьсаар байгаа атлаа засч залруулж чадсангүй. Бодит амьдрал дээр боловсролын системийн үгийн санд цогц чадамж, кинрикулим гэсэн хэдэн шинэ үг орж ирснээс цаашгүй гэхэд болно.

4. Сурах бичгийн боловсруулалт, арга зүй хоцрогдсон, нэгэн хэв загварын хэвээр байна. Ялангуяа, арга зүйн шинэчлэлт дутагдаж байна.

5. “ЕБС-д ялангуяа бага дунд ангид хэлбичгийн хичээлийг Монгол хэл, Уранзохиол гэсэн хоёр хичээл болгон салгаж зааж ирсэн нь уг хичээлүүдийн үнэ цэнэ, утга учрыг алдагдуулсан гол шалтгаан, гашиун туршлага болно. Сүүлийн үед уранзохиол (эх зохиол)д суурилсан монгол хэлийг заахаар болж байгаа нь”¹⁵ маш зүйтэй юм.

6. Мөн сургалтыг хэрэглэгчдэд хүргэх гүүр болсон багш нар маань сурах бичиг, түүний агуулгад таагүй ханддаг болсон нь стандарт, сурах бичгийг цогцоор өөрчлөх ёстой гэдгийг сануулж буй хэрэг юм. Тэр ч байтугай зарим багш сурах бичгээ ойлгохгүй байгаагаа хэв нэг хэлж байгааг ч буруутгах аргагүй. Мөн зарим сургуульд сурах бичиг авхуулчихаад огт өөр сурах бичгээс юмуу эсвэл ондоо ондоо номоор сургалт явуулж буй туршлагатай сайн багш цөөнгүй байна. Энэ нь жор үзсэн ламаас, зовлон үзсэн чавганц дээрийн үлгэр биш үү.

Монгол хэлний сургалтад асуудал (алдаа дутагдал) байна гэдэгтэй манай олон эрдэмтэн багш санал нийлж байна. Тухайлбал: МУБИС-ийн профессор Ц.Өнөрбаян, Н.Бэгз: “Эдгээр шалтгаан нь эх хэлний сургалтын үр дүнд шууд нөлөөтэй гэж үзэж

¹⁴ Н.Хавх (1991) Боловсролыг шинэчлэхэд гүн ухааны учир холбогдол // Манай Монгол сэтгүүл, №2, 19-20-р тал, Улаанбаатар.,

¹⁵ Д.Баттогтох (2009) Монгол хэл уран зохиолын харилцан шүтэлцээ // Монгол хэлбичиг. 83-91 х., 86 тал, Улаанбаатар.,

байна. Бид төр засгийн бодлоготой холбоотой энэхүү дутагдал, сул талыг дурдахдаа эх хэлний сургалтад оршиж байгаа дутагдал доголдлыг хаацайлах гэсэн хэрэг огт бишээ. Бүх шатны сургуулийн эх хэлний сургалтын агуулга, аргазүй, стандарт, хөтөлбөр, сурах бичиг болон багш бэлтгэж байгаа төрийн ба төрийн бус өмчийн сургуулийн сургалтад ч цөөнгүй дутагдал байгааг дурдах хэрэгтэй. Үүнд:

1. Шинээр боловсруулан мөрдөж байгаа стандарт, агуулгын үлгэрчилсэн хүрээний уялдаа холбоо сайнгүй учраас түүний дагуу зохиогдсон хувилбарт сурах бичгүүдийн агуулга, нэр томъёо зөрөөтэй, онолын томъёолол өөр өөр байна.
2. Монгол хэлний хичээлийн хуучин хөтөлбөрт хэлзүйн дүрэм, тодорхойлолт цээжлүүлэх, задлан ялгал хийлгэх зэрэг академик агуулга голлож байсныг өөрчилж монгол хэл, уран зохиолын боловсролын шинэ стандартад унших, сонсох, ярьж бичих чадварт суурилсан агуулгыг түлхүү оруулсан боловч агуулгын шинжлэх ухааны төвшин хүндэдсэн тархай бутархай болсон, судлаачдын дунд ч шийдвэрлэгдээгүй олон асуудал, сэдэв, нэр томъёо орсныг багш, сурагч, эцэг эхчүүд шүүмжилж байна.
3. Боловсролын шинэ стандартад ямар ч туршилтгүйгээр шууд шилжсэн учраас багш нарын мэдлэг, заах арга барил дутагдалтай, багш бэлтгэж байгаа сургуулиудын сургалтын хөтөлбөрт шинэ стандартын агуулга, аргазүйн асуудал бүрэн тусгаадаагүйгээс төгсөгчид шинэ стандартын агуулгыг сайн эзэмшиж гарахгүй гологдох тохиолдол нэлээд байна. Ер нь шинжлэх ухааны мэдлэг эзэмшүүлэх арга барил хэрэглээ нь, чадвар эзэмшүүлэх арга барилтай зөрчилдөж байна.
4. Монгол хэл, уран зохиолын багш нараас бусад мэргэжлийн багш нарын эх хэлний мэдлэг чадвар, бичиг үсгийн боловсролын ерөнхий төвшин доогуур учраас суралцагчдад олгох эх хэлний хэрэглээний чадварт муугаар нөлөөлж байна.
5. Мэдээллийн хэт нээлттэй, хяналтгүй орчноос шалтгаалж хүүхэд залуучууд ардын аман зохиол, монголын болон орчуулгын сонгодог уран зохиол унших нь мэдэгдэхүйц багасч эх хэлнийхээ ариун тансгийг мэдрэхгүй байна.
6. Эх хэлээрээ зөв оновчтой, товч тодорхой, уран яруу, энгийн ойлгомжтой ярьж бичих чадвар эзэмшүүлэхэд багш сурган хүмүүжүүлэгчид анхаарч байгаа боловч шалгаж үнэлэхдээ оновчтой шийдэл, арга хэлбэр олж чадахгүй, хуучин мэдлэг үнэлдэг арга хэлбэрээ ашигласаар байна.
7. Бага насны хүүхдэд эх хэлний яриа бичгийн чадвар, үндэсний сэтгэлгээ төлөвшөөгүй байхад нь гадаад хэл бичиг ордгоос болоод эх хэлний төгс боловсрол олгоход бэрхшээл учирч байна. Үүнээс болоод үндэсний ухамсар, сэтгэлгээний хоцрогдолд орох, яваандаа монгол хэл, соёлын алтан аргамж тасрах аюултай.
8. Эх хэлний боловсролыг бусад шинжлэх ухааны бичиг үсгийн боловсрол олгохтой зөв оновчтой уялдуулж чадахгүй байна. Математик, хими, физик, биологи, түүх гэх мэт шинжлэх ухааны бичиг үсгийн боловсролыг монгол хэлээр дамжуулан олгож байгаа учраас суралцагчдын ярих, бичих илэрхийлэх чадварт аль ч мэргэжлийн багш нар анхаарч байх ёстой.
9. Эх хэлний боловсролын, ялангуяа бичгийн боловсролын хамгийн энгийн анхан шатны чадвар бол бичгийн соёл, зөв бичих чадвар юм. Олон нийт хамгийн эхлээд энэ чадварын түвшингээр л эх хэлний боловсролыг үнэлдэг. Гэтэл сүүлийн

жилүүдэд иргэдийн бичгийн соёл, зөв бичих чадвар эрс муудсаныг захын баримтаар баталж болно”¹⁶ гэжээ.

Энэ дашрамд, ер нь сурагчид Монгол хэлний хичээлийн талаар ямар санаа бодолтой байдаг талаар санал асуулга явууллаа.

Судалгааг нийслэлийн Баянгол дүүргийн 93-р сургуулийн 11 А, 28-р сургуулийн 11 Б, 11 Д, Оюуны ундраа цогцолбор сургуулийн 11-ийн 7, Эрдмийн Өргөө цогцолборын 11 А, Б, В, Г, Сэн Ли Цэ бүрэн дунд сургуулийн 11А Сүхбаатар дүүргийн 1-р сургуулийн 11 Д, Г, Сонгино хайрхан дүүргийн 62-р сургуулийн 11А, Баянзүрх дүүргийн “Их засаг” лицей сургуулийн 11 А, Г, В, Чингэлтэй дүүргийн 23-р сургуулийн 11 А, Б, Г, Д ангийн сурагчдаас авав.

1. Та ямар хичээлийг илүү их сонирхдог вэ? (1-3 хичээл тэмдэглэнэ үү?) гэхэд нийт санал асуулгад оролцогчдийн олонхи нь англи хэл (93 %), математик (72%), нийгмийн тухай мэдлэг (61%) хичээлд дуртай гэсэн бол, мэдээлэл зүй (19%), монголын түүх (19%), монгол хэл (22%) хичээлийг тийм ч их сонирхдоггүй гэжээ.
2. Та монгол хэлний хичээлд тийм ч сонирхолтой биш бол, Яагаад? гэсэн асуултад олонхи нь, миний эзэмших мэргэжилд шууд хамаатай бус (50%), монгол хэлээ багаас сурсан учраас (20%) гэсэн байна.
3. Монгол хэлний хичээл, Тухайлбал: өгүүлбэрийг гишүүдээр зурж, тэмдэглэх нь амьдралд ямар хэрэгтэй гэж үздэг вэ? гэсэн нэгж хичээлийн үр дүнг тандсан асуултад олонхи нь, анги дэвших шалгалт өгөх (50%), алдаагүй, зөв сайхан ярьж бичих (20%), хэрэгтэй болоод заадаг байх (20%) гэжээ.
4. Монгол хэлний сайхныг хир мэдэрдэг вэ? гэсэн монгол хэлний үнэлэмж ба өсвөр үеийнхэн маань эх хэлдээ тийм таагүй , дургүй ханддаг болчихсон юмуу гэдгийг тандсан асуултад 90% нь монгол хэл бол бидний өв соёлыг хадгалагч, үлдсэн хэсэг нь монгол хэл нь яруу эгшиглэнтэй хэмээжээ. (Судалгааг графикаар <http://www.greenbough.mn/article.php?content=141&p=4> хаягаар үзнэ үү?)

Энэ бүхнээс, сургуулийн өмнөх болоод ерөнхий боловсролын сургуульд зааж буй монгол хэлний хичээлийн агуулга стандартыг цогцоор өөрчлөх нь эх хэл соёлоо хамгаалах, дархлааг тогтоох (хэлний экологийн) хамгийн чухал арга гэж үзэж байна.

Хэдийгээр Ерөнхий боловсролын 12 жилийн “Бага, дунд боловсролын стандарт ба сургалтын хөтөлбөр (киррикулим)”, монгол хэлний сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөмж гарч, “Монгол хэлний боловсролын стандартаар эх хэлний боловсролын агуулгад шинжлэх ухаанжсан агуулга давамгайлж байсныг өөрчилж, хэрэглээний агуулгатай хослуулан заах шийдлийг хийсэн. Хэдийгээр 1970-аад оны дунд үеэс яриа бичгийн дадлага хичээлийг бага, дунд ангийн монгол хэлний сургалтын хөтөлбөрт тусгаж байсан ч, өнөөг хүртэл эх хэлний сургалтыг хэт шинжлэх ухаанжсан, амьдралаас хол, хоосон дүрэм заадаг гэж шүүмжлэх явдал байсаар байна. Ийм учраас монгол хэлний боловсролын стандартын болон сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалд энэхүү харьцааг зохистой болгохыг чухалчлан үзсэн билээ”¹⁷ хэмээсэн

¹⁶ Ц.Өнөрбаян, Н.Бэгз (2011) Монгол хэлний боловсролын өнөөгийн байдал кирил монгол бичиг // Монгол судлалын чуулган, №10 (45), 9-21 тал, Улаанбаатар.,

¹⁷ Ш. Оюунцэцэг, Л. Олзвой (2011) ЕБ-ийн 12 жилийн шилжилтийн 7-р ангийн монгол хэлний сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөмж , www.mecs.gov.mn, 23 -р тал, Улаанбаатар.,

боловч нэгж хичээлийн агуулгыг ажиглахад энэ нь төдийлэн амжилтад хүрэхгүй нь бололтой.

Гадаадын хэн нэгэн нөхрийн (*Жеймс Моффет* “Бичих гэдэг нь хүн ямар нэг зүйлийн тухай хэн нэгэнтэй ярьж байгаатай адил” гэсэн байна. Монгол хэлний хичээлийн гол зорилго бол санаа бодлоо бичгээр оновчтой илэрхийлэн бичиж найруулахад сургах явдал болно.”¹⁸ хэлсэн үгийг үндэслээд төрөлх хэлнийхээ хичээлийн зорилгыг тогтооно гэдэг юу л бол доо. Ямартай ч хэлний экологийн үндсэн, тулгамдсан, адармаатай асуудлын нэг болох эх хэлээ эзэмших, эзэмшүүлэх асуудлын талаар өөрийн саналаа хэлье. Үүнд,

1. Сурах бичгийг энд тэндэхийн “эрээвэр хураавар” хүмүүс биш БСШУЯ-ны харъяа Боловсролын хүрээлэнд 10 орчим хүний бүрэлдэхүүнтэй эрдэмтэн судлаачдын байнгын ажиллагаатай баг (*их цалинтай*) ажиллаж, жинхэнэ **суралцагчдад ярианы болон бичгийн соёл эзэмшүүлж, эх хэлний боловсролоо нийгмийн харилцааны янз бүрийн орчинд бүтээлчээр хэрэглэж чаддаг цогц чадамж бүхий иргэн төлөвшүүлэх** стандарт, тогтолцоотой, сайн сурах бичиг зохиох ёстой. Дунд сургуулийн сурах бичиг, тэр дундаа эх хэлний сурах бичиг бол ховдог шунахай хүмүүсийн хоол зууш яав ч биш, харин хүний оюун тархийг тэжээгч “*шидэт аминдэм*” бүтээх ажил учраас, маш нарийн судалгаа, төвшин хоорондын ялгаа, агуулгын уялдаа, бичвэрийн сурган хүмүүжүүлэх ач холбогдол зэргийг шинжлэх ухааны үндэстэйгээр боловсруулах багийн хийх ажил. Түүнээс хэн нэг дунд сургуулийн багш сурах бичиг бичээд байдаг юм бол сурах бичгийн хэрэг юу байна. Сургууль сургууль өөрсдийн сурах бичгээр л сургалт явуулъя л даа.

2. Монгол хэлний сургуулийн өмнөх боловсролын агуулгын стандартын 80%, бага боловсролын агуулгын стандартын 60 %, суурь боловсролын агуулгын стандартын 40-50%, бүрэн дунд боловсролын агуулгын стандартын 30 % -д ярианы соёл эзэмшүүлье. Ярианы соёл эзэмшүүлнэ гэдэг нь одоогийн бидний сурах бичгийн бичвэр уншаад ярилцах ёс төдий зүйл биш. Хүн төрөлхтний аман хэл анхлан үүссэн хэлшинжлэлийн ухааны үндэс, ярих урлагийн онол, монгол гэрийн сургуулийн аман-бичгийн хэлний уламжлал (*Б.Ринчин*) -д суурилах юм.

3. Бага боловсролын монгол хэлний сурах бичгийн бичвэрийн хэлбэрт бус агуулгад, суурь боловсролын монгол хэлний сурах бичгийн бичвэрийн хэлбэр агуулгад тэгш, бүрэн дунд боловсролын монгол хэлний сурах бичгийн бичвэрийн хэлбэрт анхаарах нь чухал.

Тодруулбал, 1-4-р ангийн сурах бичгийн бичвэр хэн нэгэн Пришвиний зохиолын орчуулга (*Д.Бямбацэрэн, Д.Цогзолмаа, Б.Амарзаяа, Монгол хэл-2 “Өнгөт хэвлэл ХХК” сурах бичгийн эхний хичээл*) бус хүнтэй хэрхэн мэндлэхээс эхлээд, ахмадаа хүндлэх, аав ээжээ асрах, эх хэл, эх орноо хайрлах, бахархах үзэл санаа, чин сэтгэлийг төрүүлэхэд чиглэгдсэн агуулгатай байна. Монгол улсын ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн 2010 оны 05 сарын 21-ны “Монгол уламжлалт сэтгэлгээ, арга билгийн ухааны үндэс хичээлийн тухай” зарлигийн дагуу боловсруулсан бага боловсролын агуулга яг тохирно, үүнийг эх хэлний хичээлийн агуулгад багтаан олгох нь зүйтэй. “*Ариун ёс журам*” юм уу тусгай хичээл оруулах ямар ч шаардлаггүй.

Харин суурь боловсролын агуулгад төрөлх хэлээрээ зөв сайхан ярих, бичих чадварыг эзэмшүүлэх бол Монгол хэлний авиа , үг бүтээвэр, өгүүлбэр, эх судлал,

¹⁸ Мөн зөвлөмж, 23-р тал

найруулга зүйн онолын мэдлэгийг бүрэн дунд боловсролын агуулгад багтаан үзэх бүрэн боломжтой.

4. 1-4-р ангийн сурагчдыг “Эхийг цогцолбор, өгүүлбэр, үг болгон задалж сурах, Өгүүлбэрийг гол гишүүдийг зөв олж, тус бүрийн хэлбэр, утга үүргийг тайлбарлах, Язгуур, залгавар бүтээврийн байр, утга, үүргийг тодорхойлох, Эгийг ба гийгүүлэгч авианы нийтлэг шинжүүдийг тодорхойлох (Монгол хэлний бага боловсролын агуулгын стандартаас) чадвартай болгох нь тийм чухал гэж үү?

Юуны түрүүнд хүний хэлсэн үгийг сонсдог, ойлгодог, асуусан асуултанд товч тодорхой хариулдаг, хүнтэй зөв сайхан мэндчилдэг, ахмад настан, аав ээжээ хүндэтгэдэг, эх хэл соёл, эх орноо чин сэтгэлээсээ хайрлах чадвартай иргэнийг төлөвшүүлэх нь бага монгол хэлний бага боловсролын гол зорилго байх ёстой. Өргөн утгаар **хүний мөс чанар сайтай, эрүүл чийрэг, эрдэм боловсролтой, удам угсаагаа сайн мэддэг, ахас ихэсээ хүндэтгэдэг, сайхан ааштай, “сайн хүн”-ийг буй болгох** нь бидний ч, боловсролын байгууллагын чин зорилго юм.

5. Сурах бичгийн боловсруулалт арга зүйг шинэчлэнэ гэдэг хэлбэрийн өөрчлөлт биш. Хүүхэлдэйн киноны хэдэн баатар зурчихаад, хавтсыг нь гоё зургаар чимэглэхээр хүүхдийн ном сурах идэвх нь сайжирна гэвэл том эндүүрэл.

Аливаа шинжлэх ухааны хэл нийт хүнд ойлгомжгүй байдаг онцлогтой. Сурагчдад ерөнхий мэдлэг олгох үүднээс тухайн шинжлэх ухааны хэлийг нийтэд ойлгогдох хэмжээнд хялбаршуулсныг л сурах бичиг гэж хэлж байгаа юм. Түүнээс биш, хавтасан дээрээ сурах бичиг гэж бичээд ч агуулга, найруулгыг нь хялбаршуулж чадаагүй, магадгүй ойлгомжгүй болгосон бол тэр сурах бичиг гэж үзэх аргагүй. Сурах бичгийн гол шалгуур энэ. Ингэхдээ ямар арга зүй баримтласныг хэлж байгаа юм. Харин багш сурах бичгийн хэлийг дахин хялбаршуулж, сурагч оюутанд ойлгуулах үүрэгтэй. Багш энэ гол үүргээ л биелүүлэхгүй бол заах аргаар муу багш, ойлгомжгүй заадаг, өгөөжгүй багш гэдэг нэр зүүгээд байгаа юм. Сурах бичигт байгаа зүйлийг тэр чигээр уншиж, бичүүлж байгаа багш бол жинхэнэ багш биш, хоцрогдсон багш.


Тэгэхээр хамгийн энгийн хялбар аргаар, баттай (хэд хоноод мартчихдаг биш) мэдлэг олгох тийм арга зүйн дагуу сурах бичгийг зохионо.

Монгол хүн, монголын ард түмний гэрийн сургуулийн уламжлал, ардын сурган хүмүүжүүлэх зүйг орчин үеийн шинжлэх ухаан, боловсрол судлалын ололт амжилттай хослуулсан, хүүхдэд ярих бичих чадварыг жигд олгох, хүүхдийг хүн болохуйд суралцах агуулгатай, уялдаатай, цогц, монгол ардын ухаан мэдлэгт суурилсан “монгол” сурах бичиг, монгол стандарт хэрэгтэй байна.


Бурууг бусдаас бус өөрсдөөс хайцгаая.

Зөвхөн онолын мэдлэг болон тоон үнэлгээнд анхаарсан энэ сургалтын тогтолцоог өөрчлөх цаг нэгэнт болжээ.

Өнөөгийн Монголын боловсролын төрх байдал: Зураг 1



Зураг 1



Зураг 2

(Вонь Дун Ёнь (1999) *Бүх талын боловсрол олгох сургалтын таван талт зарчим*, Улаанбаатар.)

Аз жаргалтай амьдрах нь юунаас ч чухал. Аз жаргалыг олж авах түлхүүр оноо дүн биш, бодит чадвар юм. Бодит чадвар олгох сургалтын байдал төрх (зураг 2). Өмнөд Солонгос улс 1995 оны 5 сарын 31-нд боловсролд сүйрлийн аюул нүүрлэснийг улс даяар хүлээн зөвшөөрч, бодит чадвар олгох шинэ тогтолцоонд шилжсэнээр өнөөгийн дэвшилд хүрчээ. Одоо ч уг өдрийг боловсролын шинэтгэлийн өдөр хэмээн тэмдэглэдэг ажээ.

НОМ ЗҮЙ

Монгол хэлээр:

1. О.Адъяа (2009) Даяаршил, түүний нөлөө улс үндэстний хэлэнд // *MONGOLICA*. Vol.22 (43) 9-13х, Улаанбаатар.,
2. Ч.Базарханд (2002) Хүүхдийг эх хэлд нь сургаж байсан ардын уламжлалаас // *Монгол судлал, улстөр, эдийн засаг, гүн ухаан, хууль зүй*. Том 18 fasc 1-7 х., Улаанбаатар.,
3. Р.Батаахүү (1991) *Монголчуудын сурган хүмүүжүүлэх гэрийн уламжлал*. Ховд.
4. Д.Баттогтох (2009) Монгол хэл уран зохиолын харилцан шүтэлцээ // *Монгол хэлбичиг*. 83-91 х., Улаанбаатар.,
5. Ж.Баянсан (1999) Унаган хэлтний монгол хэлтний сурах бичиг ямар байвал зохих вэ // *ЕБС-ийн сургуулийн сурах бичгийн хэл найруулга*. 13-18 х., Улаанбаатар.,
6. Вонь Дун Ёнь (1999) *Бүх талын боловсрол олгох сургалтын таван талт зарчим*, Улаанбаатар.,
7. Ж.Дашдаваа (2009) *Монголын уламжлалт гэрийн хүмүүжил*, Улаанбаатар.,
8. Д.Доржсүрэн (1993) Гэрийн сургууль, төрийн сургууль, шашны сургууль // *Засгийн газрын мэдээ сонин* №4, №6., Улаанбаатар.
9. С.Нямсүрэн (1999) *Хэл хэлэхийн учир*. Улаанбаатар.
10. Ш. Оюунцэцэг, Д. Цогзолмаа (2011) *ЕБ-ийн 12 жилийн 3-р ангийн монгол хэлний сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөмж*, www.mecs.gov.mn

11. Ш. Оюунцэцэг, Д. Цогзолмаа, Ө. Хадаа (2011) *ЕБ-ийн 12 жилийн 4-р ангийн монгол хэлний сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөмж*, www.mecs.gov.mn
12. Ш. Оюунцэцэг, Л. Олзвой (2011) *ЕБ-ийн 12 жилийн шилжилтийн 7-р ангийн монгол хэлний сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөмж*, www.mecs.gov.mn
13. Ш. Оюунцэцэг Д. Эрдэнэсан Б. Цасанчимэг (2011) *ЕБ-ийн 12 жилийн 8-р ангийн монгол хэлний сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөмж*, www.mecs.gov.mn
14. Б.Пүрэв-Очир (1988) *Орчин цагийн монгол хэлний өгүүлбэрзүйн холбох тогтолцоо*. Улаанбаатар.,
15. Ц.Өнөрбаян, Н.Бэгз (2011) Монгол хэлний боловсролын өнөөгийн байдал кирил монгол бичиг // *Монгол судлалын чуулган*, №10 (45), Улаанбаатар.,
16. Л.Түдэв (2001) Даяаршил ба эх оронч үзлийн үндэсний дианетик // *Монгол иргэнийн үлэмж өв*. 135-144 х., Улаанбаатар.,
17. Х.Сампилдэндэв (1991) *Монгол орх гэрийн ёсон*., Улаанбаатар.
18. Ц.Сүхбаатар (2001) *Эхийн найруулга зүй (Тэргүүн дэвтэр)*, Улаанбаатар.,
19. Ш.Сүхбат (2009) *Монголчуудын сурган хүмүүжүүлэх өв уламжлал*., Улаанбаатар.,
20. Н.Хавх (2004) *Соёл иргэнийн онол*, Улаанбаатар.,
21. Н.Хавх (1991) Боловсролыг шинэчлэхэд гүн ухааны учир холбогдол // *Манай Монгол сэтгүүл*, №2, 19-20 х., Улаанбаатар.,
22. С.Хичээлтү (1998) *Нийгэм хэл шинжлэл, хэлний төрийн бодлого*, Хөх хот.,
23. Д.Хүрэлмаа (2004) 1990-ээд оны хотжилт // *Монголын хүн ам сэтгүүл*, №6, 45-52 х., Улаанбаатар.,
24. Ш.Чоймаа (2009) Хэлний экологи // *Монгол судлал*. Том.XXX (318), 125-134 х., Улаанбаатар.,
25. Ш.Шагдар (2000) *Монгол улсын боловсролын түүхийн товчоон*., Улаанбаатар.,
26. Ц.Шагдарсүрэн (2010) *Эх хэлээ эвдэхгүй юм сан*., Улаанбаатар.,
27. Г.Эрдэнэ-Очир (1998) *Ардын сурган хүмүүжүүлэх зүй*., Улаанбаатар.,

Орос хэлээр:

28. В.Г.Ветвицкий (1996) Методика обучения русскому языку как родному в средней школе// *Прикладное языкознание*. 54-57 стр, Санкт-Петербург.,
29. А.С.Гред (1996) Предмет и основные направления прикладной лингвистики // *Прикладное языкознание*. 5-12 стр., Санкт-Петербург.,

Англи хэлээр:

30. R.A.Hudson (1996) *Sociolinguistics*. Cambridge England. Cambridge University Press.

SUMMARY

Mongolian textbook and Mongolian educational standards are needed to not only combine the tradition of Mongolian people's homeschooling and pedagogy with modern science and achievement of education study, but also to give children a basis of competence to speak and write fluently and equally, to have a content which helps a child grow into a good person. These standards should be coherent and intelligent, and should pool from the general knowledge of the Mongolian people.